

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Малын тоо толгойн албан татварыг улсын дунджаас өндөр тогтоосон хэдий ч энэ нь малын тоо толгойг бууруулах, газар тариалан, мал аж ахуйн салбарын зохистой харьцааг хангах хөшүүрэг болж чадахгүй байна

АУДИТЫН СЭДЭВ: МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ  
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СЭА-2022/41-ШТА-ГА



Сэлэнгэ аймаг  
Сүхбаатар сум  
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой  
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040, Цахим хаяг:

[Enkhtuyach@audit.gov.mn](mailto:Enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036, Цахим хаяг:

[Batmunkhb@audit.gov.mn](mailto:Batmunkhb@audit.gov.mn)

Ахлах аудитор Т.Болор

Цахим хаяг: [Bolort@audit.gov.mn](mailto:Bolort@audit.gov.mn)

Аудитор Т.Одсүрэн

Цахим хаяг: [Odsurent@audit.gov.mn](mailto:Odsurent@audit.gov.mn)

Аудитор Т.Мөнхзул

Цахим хаяг: [Munkhzult@audit.gov.mn](mailto:Munkhzult@audit.gov.mn)



## **АГУУЛГА**

**Товчилсон үгийн тайлбар**

**Хүснэгт, дүрслэлийн товъёг**

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЭРХИЙН АКТ, БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГТОЙ УЯЛДУУЛАН ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН УУ?**

1.1 Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг холбогдох хууль эрхийн акт, бүс нутгийн онцлогтой уялдуулан тогтоосон эсэх?

1.2 Малын тоо толгойн албан татварын орлогыг бодитоор төлөвлөн, төвлөрүүлж, хууль, эрхийн актад нийцүүлэн, үр дүнтэй байхаар хуваарилсан уу?

**ХОЁРДУГААР БҮЛЭГ: МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРААР ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ, ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛСАН УУ?**

2.1 Малын тоо толгойн албан татварын эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хууль эрхийн актад нийцүүлэн, үр дүнтэй хэрэгжсэн эсэх?

2.2 Малын тоо толгойн албан татварын төлөвлөлт, зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналтыг хэрэгжүүлсэн үү?

**ДҮГНЭЛТ**

**ЗӨВЛӨМЖ**



## Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

## Хүснэгтийн товъёг:

- Хүснэгт 1. Малын тоо толгой, бэлчээрийн даацын судалгаа*
- Хүснэгт 2. Сумдын ИТХ-аас тогтоосон малын тоо толгойн албан татварын хэмжээ*
- Хүснэгт 3. Малын тоо толгойн албан татварын төлөвлөлт*
- Хүснэгт 4. Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөний биелэлт*
- Хүснэгт 5. Чиг үүрэгт хамааралгүй төлөвлөсөн төсөл, арга хэмжээ*
- Хүснэгт 6. 2022 онд огт хэрэгжихгүй төсөл, арга хэмжээ*

## Дүрслэлийн товъёг:

- Дүрслэл 1. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, эхний 9 сарын байдлаар*



## **АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

### **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/11 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны “ Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийв.

### **Аудитын зорилт:**

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

#### **1. Малын тоо толгойн албан татварыг холбогдох хууль, эрхийн акт, бүс нутгийн хөгжлийн онцлогтой уялдуулан төлөвлөж, хуваарилсан уу?**

1.1 Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг холбогдох хууль эрхийн акт, бүс нутгийн онцлогтой уялдуулан тогтоосон эсэх?

1.2 Малын тоо толгойн албан татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөн, төвлөрүүлж, хууль, эрхийн актад нийцүүлэн, үр дүнтэй байхаар хуваарилсан уу?

#### **2. Малын тоо толгойн албан татвараар төвлөрүүлсэн орлогыг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан уу?**

2.1 Малын тоо толгойн албан татварын эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хууль эрхийн актад нийцүүлэн, үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх?

2.2 Малын тоо толгойн албан татварын төлөвлөлт, зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналтыг хэрэгжүүлсэн үү?

### **Аудитын хамарсан хүрээ:**

Сумдын 2021-2022 оны малын тоо толгойн албан татварын орлогын ногдуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналын баримт материал болон сумын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, багийн иргэдийн Нийтийн хурал, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, СТСХ, Орон нутгийн өмчийн газар, Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

### **Аудитын арга зүй:**



Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт *MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”*, *MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”*, *MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”*, *MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”*-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан *“Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”*, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан *“Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”*-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### **Аудитын шалгуур үзүүлэлт:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Төсвийн тухай хууль,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль ,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолоор баталсан "Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай"
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”,
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

### **Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Т.Болор, аудитор Т.Одсүрэн, Т.Мөнхзул нар 2022 оны 06 дугаар сарын 27-ноос 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.



## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

УИХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг баталсан байна.

Уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “ Энэ хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж заасан боловч коронавируст цар тахлын улмаас иргэдийн орлого хомсдож, эдийн засгийн хүндрэл үүсэж байгаатай холбогдуулан Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл малын хөлийн татварыг “0” хувиар тогтоох буюу чөлөөлөх зөвлөмжийг аймаг, сумдын ИТХ, ЗДТГ-т хүргүүлсэн байна.

1990 оны эцэст Сэлэнгэ аймгийн хэмжээнд 512.5 мянган толгой мал тоологдож байсан бол 2020 онд 1,818.5 мянга, 2021 онд 1,886.7 мянган толгойд хүрсэн байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2-т заасны дагуу сумдын ИТХ-аас малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг малын төрөл тус бүрээр 2.0 мянга хүртэлх төгрөгөөр тогтоосон нь аймгийн дунджаар адуу 1.9 мянган төгрөг, үхэр 1.4 мянган төгрөг, тэмээ 1.6 мянган төгрөг, хонь 1.2 мянган төгрөг, ямаа 1.8 мянган төгрөг болж, улсын дунджаас тус бүр 1.3-8.0 дахин өндөр байна.



## **БҮЛЭГ 1. МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫГ МАЛЫН ТОО ТОЛГОЙД ҮНДЭСЛЭН НОГДУУЛААГҮЙ БӨГӨӨД ЧИГ ҮҮРЭГТ ҮЛ ХАМААРАХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ХУВААРИЛСАН БАЙНА.**

### **1.1 Тариалангийн бүс нутагт “Малын тоо толгойн албан татвар”-ыг бусад бүсүүдээс ялгавартай тогтоох замаар бүс нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байна**

**1.1.1** Тариалангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д **“тариалангийн бүс нутаг”** гэж таримал ургамал ургуулах хөрс, цаг уурын тохиромжтой нөхцөл бүрдсэн нутагт **газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийн зохистой уялдааг хангах зорилгоор төрөөс тусгайлан тогтоосон бүс нутгийг** хэлнэ гэж заасны дагуу Засгийн газрын 2018 оны 131 дүгээр **“Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай”** тогтоолоор Сэлэнгэ аймгийн **Сүхбаатар сумын 1-7 дугаар баг, Мандал сумын 1-3 дугаар багаас бусад бүх багийг** тариалангийн бүс нутгаар тогтоосон байна.

**1.1.2** Дээрх тогтоолд **тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх**, төрөлжүүлэх, **эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослон хөгжүүлэх** асуудлыг орон нутгийн хөгжлийн бодлого, аймаг, сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, тариалангийн бүс нутагт мал аж ахуй эрхэлж байгаа малчдын малыг бэлчээр, ус бүхий нутагт шилжүүлэх, мал сүргээ төрөлжүүлэх, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийж, бүх талын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах талаар тусгасан байна.

**1.1.3** Өөрөөр хэлбэл тариалангийн бүсийг тогтоогоод тухайн нутагт бэлчээрийн мал аж ахуй бус өндөр ашиг шимт эрчимжсэн мал аж ахуйг суурин болон хагас суурин байдлаар өсгөж малын тоо толгойг бууруулах, газар тариалан мал аж ахуйн салбарын зохистой харьцааг тогтоох бодлого барьснаар бэлчээрийн мал аж ахуй, газар тариалангийн салбар хооронд олон жил үргэлжилсэн зөрчил, маргаан шийдэгдэхээр зохицуулсан байна.

**1.1.4** Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.4-т **“Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж** малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, **эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж**, “Монгол мал-II” арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэж тусгасан байна.

**1.1.5** Харин аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.7-д **“Тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйн суурин, хагас суурин мал аж ахуйг эрхлэн бэлчээрийн мал аж ахуйгаас татгалзаж**, “Сэлэнгэ мах”, “Сэлэнгэ сүү”, “Нарийн нарийвтар ноост хонь” төслийг хэрэгжүүлнэ гэж тусгасан бол сумдын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар тус бүр тусгайлан зааж өгсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав./



**1.1.6** Хэдийгээр тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, малын тоог чанарт шилжүүлэх асуудлыг Засгийн газрын тогтоол, шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөр зохицуулсан боловч бүхэлдээ тариалангийн бүс нутаг болох Сэлэнгэ аймагт дээрх хууль, эрхийн акт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй байна.

**1.1.7** 2021 оны жилийн эцсийн байдлаар Сэлэнгэ аймгийн нийт малчин болон мал бүхий 10358 өрх бэлчээрийн мал аж ахуй эрхэлж, /эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг 20 аж ахуйн нэгжид 14.6 мянган малтай./ мал сүргийн тоо 1,886.7 мянган толгой /3,952.5 мянган хонин толгой/-д хүрсэн нь 1990 оныхоос 3.7 дахин, 2020 оныхоос 3.8 хувиар өссөн бөгөөд бэлчээрийн даац 3 дахин хэтэрч, тариалангийн талбай багассан, газар тариалан, мал аж ахуйн салбарын зохистой харьцаа алдагдсан хэвээр байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Малын тоо толгой, бэлчээрийн даацын судалгаа

№	Сумын нэр	2021 оны малын тоо /1000 бодит толгой/	2021 оны малын тоо /1000 хонин толгой/	Байвал зохих мал /1000 хонин толгой/	Одоо байгаа бэлчээрийн талбай /1000 га/	Бүх малд шаардлагатай бэлчээрийн талбай /1000 га/
1	Алтанбулаг	69.7	148.8	30.8	0.0	170.6
2	Баруунбүрэн	200.1	362.7	101.5	145.0	429.4
3	Баянгол	165.9	322.1	93.4	133.4	420.1
4	Ерөө	96.4	238.0	105.1	150.2	282.9
5	Жавхлант	109.2	214.3	51.4	73.4	254.0
6	Зүүнбүрэн	92.0	196.7	54.0	77.2	236.0
7	Мандал	120.5	388.4	73.8	105.4	507.9
8	Орхон	110.2	217.9	60.8	86.8	267.5
9	Орхонтуул	255.1	457.9	162.1	231.6	528.6
10	Сайхан	126.2	230.3	61.6	88.0	279.1
11	Сант	100.2	205.3	66.6	95.2	243.2
12	Сүхбаатар	22.4	70.4	0.6	0.9	82.9
13	Түшиг	54.5	126.6	32.7	46.7	163.1
14	Хүдэр	35.8	115.8	31.2	44.6	135.8
15	Хушаат	113.9	225.9	87.6	125.1	259.1
16	Цагааннуур	188.6	346.5	132.0	188.6	437.7
17	Шаамар	26.0	84.9	11.3	16.1	101.0
<b>Нийт дүн</b>		<b>1,886.7</b>	<b>3,952.5</b>	<b>1,156.5</b>	<b>1,608.2</b>	<b>4,798.8</b>

Эх сурвалж: Сумдын жилийн эцсийн малын тоо, бэлчээрийн талбай

**1.1.8** Газар тариалангийн бүс нутагт уламжлалт бэлчээрийн мал сүргийн тоо жил бүр өсөж, бэлчээрийн даац хэтэрч байгаа нь тариалангийн талбайн хөрсний үржил шимийг бууруулах, элэгдэл эвдрэл үүсгэх, тариалангийн технологи нэвтрүүлэх боломжийг алдагдуулж байна.

**1.1.9** Иймээс газар тариалан болон мал аж ахуйн салбарын тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгоор улс орон, бүс нутгийн хэмжээнд баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх нэг нөхцөл нь малын тоо толгойд ногдуулах албан татвар юм.



**1.1.10** Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1<sup>1</sup>, 6.2<sup>2</sup>-т заасны дагуу сумдын ИТХ-аас малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг 0-2.0 мянган төгрөгөөр /тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.3<sup>3</sup>-д заасны дагуу малчны амьжиргааг дэмжих зорилгоор албан татварын хэмжээг 0 төгрөгөөр тогтоосон сум байхгүй, харин Зүүнбүрэн, Түшиг сум тэмээнд албан татвар тогтоогоогүй./ малын төрөл тус бүрээр тогтоосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Сумдын ИТХ-аас тогтоосон малын тоо толгойн албан татварын хэмжээ /мянган төгрөг/

№	Сумдын нэр	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1	Алтанбулаг	1.5	1.5	1.5	0.8	0.8
2	Баруунбүрэн	2.0	0.5	2.0	0.5	2.0
3	Баянгол	2.0	2.0	2.0	2.0	2.0
4	Ерөө	2.0	1.5	1.0	1.5	2.0
5	Жавхлант	2.0	0.8	2.0	0.8	2.0
6	Зүүнбүрэн	2.0	1.0	-	1.0	1.5
7	Мандал	2.0	2.0	2.0	2.0	2.0
8	Орхон	2.0	1.0	2.0	1.0	2.0
9	Орхонтуул	2.0	1.0	2.0	1.0	2.0
11	Сайхан	2.0	1.0	2.0	0.8	1.4
10	Сант	2.0	1.0	2.0	1.0	2.0
12	Сүхбаатар	2.0	1.5	2.0	1.0	2.0
13	Түшиг	2.0	1.0	-	1.0	1.5
15	Хушаат	2.0	1.7	1.2	2.0	2.0
14	Хүдэр	1.5	1.5	1.5	0.8	1.2
16	Цагааннуур	2.0	2.0	2.0	2.0	2.0
17	Шаамар	2.0	2.0	2.0	2.0	2.0
	<b>Аймгийн дундаж</b>	<b>1.9</b>	<b>1.4</b>	<b>1.6</b>	<b>1.2</b>	<b>1.8</b>

Эх сурвалж: Сумдын ИТХ тогтоолууд

**1.1.11** Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоосон байдлыг **улсын дунджаар**<sup>4</sup> авч үзвэл адуу 0.8 мянган төгрөг, үхэр 0.5 мянган төгрөг, тэмээ 0.2 мянган төгрөг, хонь 0.9 мянган төгрөг, ямаа 1.0 мянган төгрөг байна.

**1.1.12** Харин **аймгийн дунджаар** тооцож үзвэл албан татварыг адуу 1.9 мянган төгрөг, үхэр 1.4 мянган төгрөг, тэмээ 1.6 мянган төгрөг, хонь 1.2 мянган төгрөг, ямаа 1.8 мянган төгрөгөөр тогтоосон байгаа нь улсын дунджаас тус бүр 1.3-8.0 дахин өндөр байна.

**1.1.13** Албан татварын хэмжээг **аймгийн дунджаас** доогуур тогтоосон дараах сумд байна. Үүнд:

- Адуу: Алтанбулаг, Хүдэр сум,
- Үхэр: Баруунбүрэн, Жавхлант зэрэг 8 сум,
- Тэмээ: Ерөө, Хушаат зэрэг 4 сум,
- Хонь: Баруунбүрэн, Алтанбулаг зэрэг 11 сум,

<sup>1</sup> Нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байна.

<sup>2</sup> Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно.

<sup>3</sup> Малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно.

<sup>4</sup> Эх сурвалж: <https://montsame.mn/mn/read/286826>, Татварын удирдлагын нэгдсэн систем



- Ямаа: Алтанбулаг, Хүдэр зэрэг 5 сум

**1.1.14** Хэдийгээр малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу нэг малын тоо толгойд ногдуулах албан татварын дээд хэмжээг 2.0 мянга хүртэлх төгрөгөөр тогтоон, төвлөрүүлж байгаа ч энэ нь тариалангийн бүс нутаг болох Сэлэнгэ аймагт бэлчээрийн мал аж ахуйгаас өндөр ашиг шимт эрчимжсэн мал аж ахуйд шилжих, малын тоо толгойг багасгах, улмаар газар тариалан, мал аж ахуйн салбарын зохистой харьцааг хангах, бүс нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хөшүүрэг болж чадахгүй байна.

**1.1.15** Өөрөөр хэлбэл тариалангийн бүс нутагт “Малын тоо толгойн албан татвар”-ыг бусад бүсүүдээс ялгавартай тогтоох замаар бүс нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна.

**1.2 Малын тоо толгойн албан татварыг малын тоо толгойг үндэслэн ногдуулж, төлөвлөөгүй бөгөөд төвлөрсөн орлогын тодорхой хэсгийг зориулалт бусаар зарцуулахаар хуваарилсан байна**

**1.2.1** Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д “Сумын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.8.15: малын тоо толгойн албан татвар” , Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна”, 5.2-т “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно” гэж тус тус заасан байдаг.

**1.2.2** 2020 оны жилийн эцэст Сэлэнгэ аймгийн хэмжээнд тоологдсон 1,818.5 мянган толгой малд сумдын ИТХ-аас малын төрөл тус бүрээр тогтоосон 0-2.0 мянган төгрөгөөр тооцож, албан татварыг ногдуулж, төлөвлөх ёстой. Малын тоо толгойн албан татварын ногдуулалт, төлөвлөлтийг сум тус бүрээр харуулбал:



Хүснэгт 3. Малын тоо толгойн албан татварын төлөвлөлт

/мянган төгрөг/

№	Сумын нэр	2020 оны жилийн эцсийн малын тоо	2021			2021 оны жилийн эцсийн малын тоо	2022		
			Ногдуулбал зохих албан татвар	Батлагдсан төлөвлөгөө	Зөрүү		Ногдуулбал зохих албан татвар	Батлагдсан төлөвлөгөө	Зөрүү
1	2	3	4	5	6	9	10	11	12
1	Алтанбулаг	64.2	60,622.6		(60,622.6)	69.7	66,647.8	25,000.0	(41,647.8)
2	Баруунбүрэн	185.9	208,953.0		(208,953.0)	200.1	214,773.5	-	(214,773.5)
3	Баянгол	168.8	337,656.0		(337,656.0)	165.9	331,832.0	100,000.0	(231,832.0)
4	Ерөө	92.3	159,223.5		(159,223.5)	96.4	164,968.0	150,000.0	(14,968.0)
5	Жавхланта	102.5	137,140.4		(137,140.4)	109.2	143,167.6	104,184.4	(38,983.2)
6	Зүүнбүрэн	89.5	112,119.5		(112,119.5)	92.0	113,803.0	88,868.0	(24,935.0)
7	Мандал	129.8	259,564.0		(259,564.0)	120.5	240,976.0	254,531.7	13,555.7
8	Орхон	108.6	159,911.0	70,000.0	(89,911.0)	110.2	156,934.0	100,500.3	(56,433.7)
9	Орхонтуул	231.1	333,899.0		(333,899.0)	255.1	357,788.0	-	(357,788.0)
10	Сайхан	120.0	133,238.6	20,000.0	(113,238.6)	126.2	138,003.8	50,000.0	(88,003.8)
11	Сант	95.3	133,935.0		(133,935.0)	100.2	138,011.0	133,935.0	(4,076.0)
12	Сүхбаатар	22.4	36,064.0		(36,064.0)	22.4	36,290.0	20,479.0	(15,811.0)
13	Түшиг	61.5	75,334.5		(75,334.5)	54.5	65,708.5	-	(65,708.5)
14	Хушаат	102.9	201,190.5		(201,190.5)	113.9	222,587.3	423,587.0	200,999.7
15	Хүдэр	35.9	42,527.3		(42,527.3)	35.8	43,215.5	-	(43,215.5)
16	Цагааннуур	182.4	120,326.5	119,985.2	(341.3)	188.6	377,268.0	355,041.2	(22,226.8)
17	Шаамар	25.5	51,020.0		(51,020.0)	26.0	52,052.0	-	(52,052.0)
	<b>Дүн</b>	<b>1,818.5</b>	<b>2,562,725.4</b>	<b>209,985.2</b>	<b>(2,352,740.2)</b>	<b>1,886.7</b>	<b>2,864,026.0</b>	<b>1,806,126.6</b>	<b>(1,057,899.4)</b>

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоол, малын тоо, албан татварын хэмжээ

1.2.3 Хэдийгээр Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн дагаж мөрдөхөөр баталсан ч 2021 онд аймгийн хэмжээнд дараах 3 сум нийт 209,985.2 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, бусад сумдын ИТХ-ын тогтоол нь захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй гэх үндэслэлээр орлого төлөвлөөгүй байна. Үүнд:

- Орхон сум 70,000.0 мянган төгрөг,
- Сайхан сум 20,000.0 мянган төгрөг,
- Цагааннуур сум 119,985.2 мянган төгрөг гэх мэт.

1.2.4 Харин 2021 оны жилийн эцэст аймгийн дүнгээр тоологдсон нийт 1,886.7 мянган толгой малд сумдын ИТХ-аас баталсан албан татварын хувь хэмжээгээр тооцож, 2022 онд 2,864,026.0 мянган төгрөг ногдуулахаас дараах 5 сумаас бусад 12 сум нийт 1,806,126.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Баруунбүрэн,
- Түшиг
- Орхонтуул
- Хүдэр,
- Шаамар сумд /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./

1.2.5 Өөрөөр хэлбэл 2022 онд сумын төсвийн татварын орлогын бүрэлдэхүүн хэсэг болох малын тоо толгойн албан татварыг дээрх 5 сум огт ногдуулаагүй бол Мандал сум 13,555.7 мянган төгрөг, Хушаат сум 200,999.7 мянган төгрөгөөр илүү, бусад сумд тус бүр 4,076.0-357,788.0 мянган төгрөгөөр дутуу тооцсоноос аймгийн дүнгээр 1,057,899.4 мянган төгрөгөөр дутуу ногдуулсан байна.



**1.2.6** Малын тоо толгойн албан татвараар сумдууд 2021 онд 209,985.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж 1,389,067.8 мянган төгрөг, 2022 онд 1,806,126.6 мянган төгрөг төлөвлөж, эхний 9 сарын байдлаар 1,025,943.8 мянган төгрөг төвлөрүүлсэн бол оны эцэст хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,348,562.4 мянган төгрөгийн албан татварыг төвлөрүүлэхээр байна. Төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөний биелэлт.

/мянган төгрөг/

№	Сумын нэр	2021 он			2022 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Зөрүү
1	Алтанбулаг		29,483.7	29,483.7	25,000.0	53,808.2	28,808.20
2	Баруунбүрэн		167,730.9	167,730.9	-	46,120.3	46,120.30
3	Баянгол		232,903.4	232,903.4	100,000.0	99,536.2	(463.80)
4	Ерөө		109,523.5	109,523.5	150,000.0	135,499.8	(14,500.20)
5	Жавхланта		43,530.4	43,530.4	104,184.4	68,944.2	(35,240.20)
6	Зүүнбүрэн		76,146.0	76,146.0	88,868.0	75,840.6	(13,027.40)
7	Мандал		133,066.5	133,066.5	254,531.7	147,830.8	(106,700.90)
8	Орхон	70,000.0	91,396.5	21,396.5	100,500.3	111,702.3	11,202.00
9	Орхонтуул		96,086.2	96,086.2	-	80,723.9	80,723.90
10	Сайхан	20,000.0	52,877.0	32,877.0	50,000.0	99,107.3	49,107.30
11	Сант		85,612.0	85,612.0	133,935.0	29,216.5	(104,718.50)
12	Сүхбаатар		12,976.8	12,976.8	20,479.0	14,768.4	(5,710.60)
13	Түшиг		42,904.0	42,904.0	-	8,384.0	8,384.00
14	Хушаат		63,320.3	63,320.3	423,587.0	164,678.3	(258,908.70)
15	Хүдэр		32,535.4	32,535.4	-	3,684.6	3,684.60
16	Цагааннуур	119,985.2	76,190.2	(43,795.0)	355,041.2	171,375.1	(183,666.10)
17	Шаамар		42,785.0	42,785.0	-	37,341.9	37,341.90
	<b>Дүн</b>	<b>209,985.2</b>	<b>1,389,067.8</b>	<b>1,179,082.6</b>	<b>1,806,126.6</b>	<b>1,348,562.4</b>	<b>(457,564.2)</b>

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоол, малын тоо, албан татварын хэмжээ

**1.2.7** Ингэснээр малын тоо толгойн албан татвараар 2021 онд 2,562,725.4 мянган төгрөг ногдуулж, төлөвлөхөөс 209,985.2 мянган төгрөг төлөвлөж, 1,389,067.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн бол 2022 онд 2,864,026.0 мянган төгрөгийн албан татвар ногдуулахаас 1,806,126.6 мянган төгрөг төлөвлөж, эхний 9 сарын байдлаар 1,025,943.8 мянган төгрөг төвлөрүүлж, оны эцэст хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,348,562.4 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./

**1.2.8** Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1: хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах ... орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасан атал малын тоо толгойн албан татварыг өмнөх онд тоологдсон малын тоонд үндэслэн бодитоор ногдуулж, төлөвлөөгүй бөгөөд үүнээс шалтгаалан малын тоо толгойн албан татварыг 2021 онд 1,173,657.5 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн бол 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 1,515,463.6 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлэхээр байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./

**1.2.9** Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.15 дахь заалтад “Малын тоо толгойн албан татвар”-ыг сумын төсвийн орлогод төвлөрүүлж, 60 дугаар зүйлийн



60.2.8<sup>5</sup> дахь заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр байхаар зохицуулагдсан байдаг.

**1.2.10** Малын тоо толгойн албан татвараар 2021 онд 1,389,067.9 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зарцуулаагүй бөгөөд харин 2022 онд дээрх үлдэгдэл болон тайлант онд төвлөрүүлэхээр баталсан 1,806,126.6 мянган төгрөг, нийт 3,195,194.5 мянган төгрөгийн эх үүсвэрээс 2,306,414.2 мянган төгрөгийг ОНХС-ийн 73 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эцэслэн баталсан байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 2, 3-т харуулав/*

**1.2.11** Харин 888,780.3 мянган төгрөгийн орлогын зарцуулалтыг тодорхой төлөвлөж, хуваарилаагүй байгаа нь уг албан татварын орлогыг ОНХС-д бус бусад зардалд, өөрөөр хэлбэл зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.

**1.2.12** Малын тоо толгойн албан татварын орлогын 2,306,414.2 мянган төгрөгийг ОНХС-ийн 73 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас дараах 1,527,694.0 мянган төгрөгийн 59 төсөл, арга хэмжээ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5-д заасан чиг үүрэг буюу зориулалтын дагуу зарцуулагдахаар төлөвлөгдсөн байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 4-т харуулав/* Үүнд:

- *Бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр 7,527.7 мянган төгрөгийн 2,*
- *Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр 396,512.5 мянган төгрөгийн 13,*
- *Малын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 390,586.8 мянган төгрөгийн 12,*
- *Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 154,000.0 мянган төгрөгийн 8,*
- *Малын чанарыг сайжруулах чиглэлээр 369,750.0 мянган төгрөгийн 6,*
- *Гэмт халдлага, гамшгаас хамгаалах чиглэлээр 62,500.0 мянган төгрөгийн 4,*
- *Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр 7,391.6 мянган төгрөгийн 2,*
- *Тэжээлийн нөөц бүрдүүлэх чиглэлээр 30,400.0 мянган төгрөгийн 2,*
- *Хортон мэрэгчидтэй тэмцэх /байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/ чиглэлээр 29,700.0 мянган төгрөгийн 2,*
- *Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа чиглэлээр 79,325.4 мянган төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ баталсан байна.*

**1.2.13** Харин дээрх журамд заасан чиг үүрэгт үл хамаарах 778,720.2 мянган төгрөгийн дараах 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр сумдын ИТХ-аас баталсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5<sup>6</sup> дахь заалтыг зөрчсөн байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 4-т харуулав./*

<sup>5</sup> малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.

<sup>6</sup> Бэлчээрийн менежментийг сайжруулах, Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/, Малын эрүүл мэндийг хамгаалах, Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, Малын чанарыг сайжруулах, Гэмт халдлага, гамшгаас хамгаалах, Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, Малын тэжээлийн ургамал тариалах, Тэжээлийн нөөц бүрдүүлэх, Байгаль орчныг хамгаалах, Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах, Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа,



Хүснэгт 5. Чиг үүрэгт хамааралгүй төлөвлөсөн төсөл, арга хэмжээ

/мянган төгрөг/

д/д	Сумдын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Баруунбүрэн	Төв замын камержуулалт	10,000.0
2	Ерөө	Сүү, сүүн бүтээгдэхүүний тоног төхөөрөмж худалдан авах	100,000.0
3	Зүүнбүрэн	Малчдад сургалт сурталчилгаа, төрийн үйлчилгээ явуулах байрыг засаж тохижуулах	10,000.0
4	Зүүнбүрэн	Байгалийн гамшиг ослын үед авран хамгаалах, зам даваа засах, тусгай тоног төхөөрөмж	95,000.0
5	Орхонтуул	Ногооны хүлэмж худалдан авах	10,000.0
6	Орхонтуул	Хонгор-овоо 3-р багийн байр засварлах	14,600.0
7	Орхонтуул	Тоног төхөөрөмжийн зардал /лед дэлгэц/	20,000.0
8	Сант	Мухар бүдүүний голын гармын засварлалт	20,000.0
9	Сант	Замыг засаж сайжруулах	10,000.0
10	Сүхбаатар	Малын тоо толгойн албан татварын зарлага /төсөл, арга хэмжээгээр задалж төлөвлөөгүй/	20,479.0
11	Хушаат	Зам даваа засах	93,600.0
12	Хушаат	Хэсгийн цагдаа, багийн засаг дарга нарыг унаажуулах	25,000.0
13	Цагааннуур	Хогийн цэгийн хашаажуулалт, камержуулалт	171,289.3
14	Цагааннуур	Гэр чулууны давааны авто замыг сайжруулж дайрган хучилт хийх	178,751.9
	<b>Дүн</b>		<b>778,720.2</b>

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоол

**1.2.14** Мандал сум нь малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлэх 50,000.0 мянган төгрөгийн дараах 3 арга хэмжээг ОНХС-д бус сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны зардлын зүйл дээр төлөвлөж баталсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6.1<sup>7</sup> дэх заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Мал аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг тусламж 30,000.0 мянган төгрөг,
- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 10,000.0 мянган төгрөг,
- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа 10,000.0 мянган төгрөг.

**1.2.15** 2022 онд малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр ОНХС-гаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт 963,838.0 мянган төгрөгийн өртөг бүхий 47 төсөл арга хэмжээг тусгаж, төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6<sup>8</sup> дахь заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 5-д харуулае/

<sup>7</sup> ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй: Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг энэхүү журмын 4.5-д заасан зорилгоор;

<sup>8</sup> орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.



## БҮЛЭГ 2. 2022 ОНД МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 23.2 ХУВЬ НЬ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

### 2.1 2022 онд бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээний 5.6 хувь /санхүүжилтийн 10.7 хувь/ нь зориулалт бус байна

**2.1.1** Малын тоо толгойн албан татвараар 2021 онд төвлөрүүлсэн 1,389,067.8 мянган төгрөг болон 2022 онд төвлөрүүлэхээр төлөвлөсөн 1,806,126.6 мянган төгрөг зэрэг нийт 3,195,194.5 мянган төгрөгийн эх үүсвэрээс 2,306,414.2 мянган төгрөгийн өртөг бүхий 73 төсөл, арга хэмжээг ОНХС-аар дамжуулан 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.

**2.1.2** Үүнээс 2022 оны эхний 9 сарын байдлаар 677,305.2 мянган төгрөгийн 14 төсөл арга хэмжээ бүрэн, 766,081.4 мянган төгрөгийн 20 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэн бол 819,621.4 мянган төгрөгийн 39 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 6-д харуулав/

Дүрслэл 1. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, эхний 9 сарын байдлаар /мянган төгрөг/



**2.1.3** Харин 2022 оны жилийн эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр тооцож үзэхэд 1,889,262.6 мянган төгрөгийн 56 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 381,600.0 мянган төгрөгийн 17 төсөл арга хэмжээ огт хэрэгжихгүй байхаар байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 7-д харуулав/ Хэрэгжихгүй төсөл арга хэмжээ нь нийт төсөл, арга хэмжээний 23.2 хувийг эзэлж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. 2022 онд огт хэрэгжихгүй төсөл, арга хэмжээ

/мянган төгрөг/

№	Сумдын нэр	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Тайлбар
1	Баруунбүрэн	Хортон мэрэгчидтэй тэмцэх	20,000.0	Цаг хугацаанаас хамаарч хэрэгжих боломжгүй болсон.
2	Ерөө	Сүү, сүүн бүтээгдэхүүний тоног төхөөрөмж худалдан авах	100,000.0	Худалдан авах ажиллагаа зарласан боловч санал ирүүлээгүй.
3	Жавхлант	Бэлчээрийн менежментийг сайжруулах	7,188.6	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй



4	Жавхлант	Усан хангамжийг нэмэгдүүлэх	5,000.0	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
5	Жавхлант	Малын эрүүл мэндийг хамгаалах	33,686.8	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
6	Жавхлант	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	14,000.0	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
7	Жавхлант	Малын чанарыг сайжруулах	24,750.0	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
8	Жавхлант	Гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх	3,000.0	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
9	Жавхлант	Гамшгаас хамгаалах	10,000.0	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
10	Жавхлант	Хур тунадас нэмэгдүүлэх	2,391.6	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
11	Жавхлант	Малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх	10,400.0	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
12	Жавхлант	Хортон мэрэгчидтэй тэмцэх	9,700.0	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
13	Жавхлант	Малчдад сургалт, сурталчилгааны зардал, гарын авлага	16,983.0	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
14	Хушаат	Малын ангилалтанд ашиглах ээмэг, чип худалдан авах	19,500.0	Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
15	Хушаат	Ар тойлбод мал эрүүлжүүлэх халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төв байгуулах	40,000.0	Худалдан авах ажиллагаа зарласан боловч санал ирүүлээгүй.
16	Хушаат	Хур бороо нэмэгдүүлэх зардал	5,000.0	Хур элбэгтэй жил учраас шаардлага гараагүй.
17	Цагааннуур	1, 3 дугаар багийн мал угаалгын ванн	60,000.0	Худалдан авах ажиллагаа зарласан боловч санал ирүүлээгүй.
<b>Дүн</b>			<b>381,600.0</b>	

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоол, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баримтууд

**2.1.4** Хүснэгтээс харахад иргэдээс санал авч эрэмбэлж төлөвлөөгүйгээс 156,600.0 мянган төгрөгийн 12, худалдан авах ажиллагааны санал ирээгүйгээс 200,000.0 мянган төгрөгийн 3, цаг хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс 20,000.0 мянган төгрөгийн 1, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж 5,000.0 мянган төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ тус тус хэрэгжихээргүй байна.

**2.1.5** Өөрөөр хэлбэл ОНХС-аар дамжуулан зарцуулж буй зарцуулалтад иргэдийн саналыг урьдчилан авч эрэмбэлээгүй, төсөв тооцоо, үнийн судалгааг бодитоор хийгээгүй, худалдан авах ажиллагааг оройтож зарласан зэрэг нь төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байх үндсэн нөхцөл болж байна.

**2.1.6** Малын тоо толгойн албан татварын орлогыг холбогдох журамд заасны дагуу малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, үүлдэр угсааг сайжруулах, худаг ус гаргах зэрэг зориулалтын төсөл, арга хэмжээнд зарцуулж байна.

**2.1.7** Гэвч зарим сумдууд мал, малчдад зориулсан арга хэмжээ гэх нэрийдлээр малын тоо толгойн татварын хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт үл хамаарах 778,720.2 мянган төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс 202,379.1 мянган төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, зориулалт бусаар зарцуулсан нь



Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын 4.6.1<sup>9</sup> дэх заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Орхонтуул сум малын эрүүл мэндийн хамгаалах халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малчдад зориулсан сургалт сурталчилгаа явуулах гэх нэрийдлээр “Тоног төхөөрөмж худалдан авах” төсөл арга хэмжээнд 20,000.0 мянган төгрөг,
- Сант сум малчдад зориулсан гэх “Мухар бүдүүний голын гармын хэсгийг саадгүй зорчдог болгох” төсөл арга хэмжээнд 10,000.0 мянган төгрөг,
- Хушаат сум “Хэсгийн цагдаа, багийн засаг дарга нарыг унаажуулах” төсөл арга хэмжээнд 25,000.0 мянган төгрөг,
- Цагааннуур сум “Хогийн цэгийн хашаажуулалт, камержуулалт”-д 132,379.1 мянган төгрөг, “Гэр чулууны давааны авто замыг сайжруулж, дайрган хучилт хийх”-д 15,000.0 мянган төгрөг зэрэг 2 төсөл арга хэмжээнд 147.379.1 мянган төгрөг гэх мэт.

**2.1.8** 2022 онд шинээр хэрэгжүүлэх нийт 2,306,414.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 73 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс эхний 9 сарын байдлаар 1,486,792.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 8-д харуулав./ Үүнд:

- 600,041.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар,
- 579,512.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,
- 307,239.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар гэх мэт.

**2.1.9** Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах харьцуулалтын аргаас зайлсхийж, Сант сум нь 1 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хуваан төлөвлөж, шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.4<sup>10</sup>, 8.5<sup>11</sup> дахь заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- “Зэгстэйд худаг гаргах” 31,000.0 мянган төгрөгийн 1 төсөл арга хэмжээг худгийн цооног гаргах 19,000.0 мянган төгрөг, “Худгийн тохижилт” 12,000.0 мянган төгрөг гэж 2 хуваасан байна.

**2.1.10** Ижил төстэй төсөл, арга хэмжээг харилцан адилгүй үнэ, өртгөөр төлөвлөж, хэрэгжүүлсэн байгаа нь хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Тухайлбал худаг гаргах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн өртгийн судалгааг харьцуулан авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Баянгол сум 3 худгийн ажлыг 95,730.6 мянган төгрөгөөр,

<sup>9</sup> Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг энэхүү журмын 4.5-д заасан зорилгоор;

<sup>10</sup> Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

<sup>11</sup> Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.



- Хүдэр сум 1 худгийг гадна талдаа барилгатай, мал услах онгоцтойгоор 19,000.0 мянган төгрөгөөр,
- Сант сум 1 худгийг 19,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гаднах тохижилтыг 12,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий өөр төсөл арга хэмжээгээр хэрэгжүүлэхээр,
- Орхон сум 2 худгийн зөвхөн цооногийг 40,512.5 мянган төгрөгөөр гаргаж, барилгын ажлыг малчдын бүлгийн өөрсдийн хөрөнгөөр гэх мэт.

**2.1.11** Малын тоо толгойн албан татварын орлогоор төсөл, арга хэмжээг сумдын ЗДТГ-ын даргын тушаалаар данс бүртгэлд тусгасан бол Баруунбүрэн сум дараах 2 төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгаагүй нь хөрөнгө эзэнгүйдэх, хадгалалт, хамгаалалт сулрах эрсдэлийг үүсгэж байна. Үүнд:

- “Сайн чанарын хээлтүүлэгч бухан бяруу авах” 30,000.0 мянган төгрөг,
- “Малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх” 20,000.0 мянган төгрөг.

## **2.2 Малын тоо толгойн албан татварын бүрдүүлэлт, зарцуулалтад дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна**

**2.2.1** Малын тоо толгойн албан татвар нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.15<sup>12</sup> дахь заалтын дагуу сумын төсвийн орлогод төвлөрүүлэх татварын 1 төрөл тул түүний ногдуулалт, төлөвлөлт, бүрдүүлэлтэд Татварын ерөнхий хуулийн 75 дугаар зүйлийн 75.1.2<sup>13</sup>, 75.1.3<sup>14</sup>-т заасан татварын албаны чиг үүргийн дагуу татварын байгууллагын зүгээс хяналт шалгалт гүйцэтгэх нь зайлшгүй юм.

**2.2.2** Гэтэл “Малын тоо толгойн албан татварын тухай” хууль хэрэгжээд 2 жил болж байхад татварын байгууллагын зүгээс уг хуулийн хэрэгжилтэд огт хяналт шалгалт хийгээгүй, үр нөлөө бүхий арга хэмжээг хэрэгжүүлээгүйгээс аймгийн дүнгээр 2021 онд 1,389,0687.8 мянган төгрөгийн, 2022 онд 1,348,562.4 мянган төгрөгийн орлогыг тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

**2.2.3** Нөгөө талаас малын тоо толгойн албан татварын орлогыг ОНХС-д бүрэн төвлөрүүлж зарцуулахаар зохицуулагдсан тул Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтын дагуу төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт, аудит, ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд тус тус хяналт тавих учиртай.

**2.2.4** Аудитын дүнгээс харахад “Малын тоо толгойн албан татвар”-ын ногдуулалт, төлөвлөлт, бүрдүүлэлт, уг эх үүсвэрийн зарцуулалтад аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийж, гүйцэтгээгүй байна.

<sup>12</sup> Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: Малын тоо толгойн албан татвар.

<sup>13</sup> татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

<sup>14</sup> төсвийн орлогыг бүрдүүлэх.



**2.2.5** Харин Цагааннуур, Хушаат, Хүдэр сумдын ИТХ-аас дээрх хуулийн хэрэгжилт, үр дүнд тодорхой хэмжээний хяналт шалгалт хийсэн бол Баруунбүрэн, Орхонтуул, Хушаат сумдын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс хяналт огт хийгдээгүй байна.

**2.2.6** Дээр дурдсанчлан холбогдох байгууллагуудаас “Малын тоо толгойн албан татвар”-ын ногдуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалтыг хийж гүйцэтгээгүйгээс татварыг дутуу ногдуулж, төвлөрүүлэх, төвлөрсөн орлогыг зориулалт бусаар зарцуулах, холбогдох хууль эрхийн актыг зөрчих зэрэг зөрчлүүд гарсаар байна.

### **АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ:**

Аудитаар илэрсэн нийт **1,770,389.3** мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлээ. /Дэлгэрэнгүйг Судалгаа 9-д харуулав./ Үүнд:

- Малын тоо толгойн албан татварыг:
  - Мандал, Хушаат сумд нийт 214,555.4 мянган төгрөгөөр илүү ногдуулсан,
  - Алтанбулаг, Баянгол, Ерөө, Жавхлант, Зүүнбүрэн, Орхон, Сайхан, Сант, Сүхбаатар, Цагааннуур сумд нийт 538,917.3 мянган төгрөгөөр дутуу ногдуулсан.
  - Баруунбүрэн, Орхонтуул, Түшиг, Хүдэр, Шаамар сумд ногдуулбал зохих 733,537.5 мянган төгрөгийн татварыг огт ногдуулаагүй байна.
- Орхонтуул, Сант, Хушаат, Цагааннуур сумд “Малын тоо толгой албан татвар”-аар хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй **202,379.1** мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн.
- Мандал сум нь малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлэх **50,000.0** мянган төгрөгийн 3 арга хэмжээг сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны зардалд төлөвлөж, баталсан.
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах харьцуулалтын аргаас зайлсхийж Сант сум **31,000.0** мянган төгрөгийн худаг гаргах төсөл, арга хэмжээг 2 арга хэмжээ болгон хуваан төлөвлөж, худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

### **ДҮГНЭЛТ:**

**Аудитаар илрүүлсэн нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

1. Малын тоо толгойн албан татварыг улсын дунджаас өндөр тогтоосон хэдий ч энэ нь бүс нутгийн хөгжлийн бодлогыг хангах, малын тоо толгойг бууруулах, газар тариалан, мал аж ахуйн салбарын зохистой харьцааг хангах хөшүүрэг болж чадахгүй байна.
2. Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг тариалангийн бүс нутгийн онцлогтой уялдуулан бусад бүс нутгаас ялгаатай буюу 2.0 мянган төгрөгөөс дээш нэмэгдүүлэн тогтоох хууль, эрх зүйн үндэслэл бүрдээгүй байна.



3. Сэлэнгэ аймагт уламжлалт бэлчээрийн мал сүргийн тоо жил бүр өсөж, бэлчээрийн даац 3 дахин хэтэрсэн бөгөөд үр тариа, хүнсний ногоо тариалах талбай багассан байна.
4. Малын тоо толгойн албан татварыг тоологдсон малын тоо толгойд үндэслэн ногдуулаагүйгээс орлого дутуу төвлөрүүлсэн байна.
5. Баруунбүрэн, Түшиг, Орхонтуул, Хүдэр, Шаамар сумд малын тоо толгойн албан татварыг ногдуулж, төлөвлөөгүй байна.
6. Малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
7. Малын тоо толгойн албан татварын эх үүсвэрээр 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.
8. ОНХС-аар дамжуулан зарцуулж буй зарцуулалтад иргэдийн саналыг урьдчилан авч эрэмбэлээгүй, төсөв тооцоо, үнийн судалгааг бодитоор хийгээгүй, худалдан авах ажиллагааг оройтож зарласан зэрэг нь төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх үндсэн нөхцөл болж байна.
9. Зарим сумд малын тоо толгойн албан татварын эх үүсвэрээр бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй нь хөрөнгө эзэнгүйдэх, хадгалалт, хамгаалалт сулрах эрсдэлийг үүсгэж байна.
10. Малын тоо толгойн албан татварын ногдуулалт, төлөвлөлт, зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

## **ЗӨВЛӨМЖ:**

**Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:**

### **Сумдын ИТХ-ын дарга нарт**

1. “Малын тоо толгойн албан татвар”-ыг бусад бүсүүдээс ялгавартай тогтоох хууль, эрх зүйн зохицуулалт хийх замаар тариалангийн бүс нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх боломжийг судалж, холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах.
2. “Малын тоо толгойн албан татвар”-ын орлогыг зөвхөн ОНХС-ийн эх үүсвэр байхаар болон хууль, тогтоомжид заасан шаардлагыг хангасан, холбогдох чиг үүргийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлах.
3. “Малын тоо толгойн албан татвар”-ын эх үүсвэрийг бүс нутгийн хөгжлийн онцлог, Засгийн газрын болон аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлд түлхүү байдлаар зарцуулахаар төлөвлөж, батлах.
4. “Малын тоо толгойн албан татвар”-ын ногдуулалт, бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийж, үр дүнг үнэлж байх.

### **Сумдын Засаг дарга нарт**

1. Малын тоо толгойн албан татварыг малын тоо толгойд үндэслэн бодитоор ногдуулан, төлөвлөж, бүрдүүлэх.



2. Малын тоо толгойн албан татварын эх үүсвэрийг ОНХС-д төвлөрүүлж, шаардлага хангасан, зориулалтын төсөл, арга хэмжээнд зарцуулах замаар үр нөлөөг сайжруулах.
3. Иргэдийн саналаар баталгаажсан, төсөвт өртөг, зах зээлийн үнийн судалгаа нь урьдчилан хийгдсэн төсөл, арга хэмжээг ОНХС-д төлөвлөн, малын тоо толгойн албан татварын эх үүсвэрээр санхүүжүүлэх.
4. Малын тоо толгойн албан татварын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, төсөвт өртгийг үндэслэн зохион байгуулах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Т.БОЛОР

Т.ОДСҮРЭН

Т.МӨНХЗУЛ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/18

Сүхбаатар сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.
4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Т.Болор/-д үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Батмөнх/-т даалгасугай.



Ч.ЭНХТУЯА

018810018

C:\Users\Bichig hereg\Tushaal 2022.docx



### ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРААС ИРҮҮЛСЭН САНАЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
АЛТАНБУЛАГ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА

213201 Алтанбулаг сум, Сэлэнгэ аймаг  
Утас: 7036-6059, Факс: 7036-6091

2022.11.01 № 01/200  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН  
ГАЗАРТ

“Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудит хийсэн тухай ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцаад нэмэх саналгүй болохыг уламжилж байна.



Н.ОТГОНЦОГ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
БАРУУНБҮРЭН СУМЫН  
ЗАСАГ ДАРГА

213200 Сэлэнгэ аймаг, Баруунбүрэн сум,  
Утас:

2022.11.01 № 229  
танай 2022.11.23-ны № 152-т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд хургуулэх санал байхгүй болно.



Ц.СЭЛЭНГЭ



СЭЛЭНГЭ АЙМАГ  
БАЯНГОЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА

43060 Баянгол сум, Баруун хараа,  
Утас/Факс: (976) 7036 9201

2022.11.01 № 454  
танай 2022.11.23-ны № 152-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Холбогдох санал байхгүй болно.



Р.БАТЖАРГАЛ



СЭЛЭНГЭ АЙМАГ  
ЖАВХЛАНТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА


213207 Жаргалант, Жавхлانت сум,  
Утас:

И-мэйл: javkhlant@selenge.gov.mn

2022.12.01 № 01/178  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАРТ

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Холбогдох санал байхгүй.



Ц.ДАРХАНБААТАР



  
**СЭЛЭНГЭ АЙМАГ  
ЗҮҮНБҮРЭН СУМЫН  
ЗАСАГ ДАРГА**

213213 Сэлэнгэ аймаг, Зүүнбүрэн сум,  
Утас:

2022.12.01 № 02/302  
танай 2022.11.29 -ны № 152 -Т

**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын төсөлд нэмэх санал байхгүй болно.

  
ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ **Б.БАТЧУЛУУН**

  
**СЭЛЭНГЭ АЙМАГ  
МАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА**

43030 Сэлэнгэ аймаг, Мандал сум, Зүүнхараа,  
Утас/Факс: (976) 7036 7140, И-мэйл: mandal@selenge.gov.mn

2022.12.01 № 02/491  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ**

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлүүдтэй танилцлаа. Ямар нэгэн саналгүй болно.

  
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ **Л.МӨНХБАТ**

  
**СЭЛЭНГЭ АЙМАГ  
ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА**

213213 Нарт, Орхон сум  
Утас/Факс: (01-3651) 27-71

2022.12.01 № 1/242  
танай 2022.11.28 -ны № 152 -Т

**СЭЛЭНГЭ АЙМАГ  
ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт үр дүн гүйцэтгэлд хийгдсэн аудитын төсөлтэй танилцлаа. Санал байхгүй болно.

  
**Т.БАТ-ОРХОН**

  
**СЭЛЭНГЭ АЙМАГ  
ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА**

213200 Орхонтуул сум, Сэлэнгэ аймаг,  
Утас:  
Orkhontuul@selenge.gov.mn

2022.12.01 № 1/471  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ**

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

  
**П.БАТБААТАР**



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Хариу хүргүүлэх тухай

"Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Манай сумын хувьд Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д "Сумын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.8.15. малын тоо толгойн албан татвар", Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна, 5.2-т "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно" гэж тус тус заасан байсныг дутуу төлөвлөсөн гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа тул ирэх оны төсөвт уг алдааг дахин гаргахгүй ажиллахаа үүгээр мэдэгдэж байна. Мөн холбогдох санал байхгүй болно.



Б.МӨНХБОЛД



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Хушаат 2-р баг, Сант сум, Сэлэнгэ аймаг 43151  
Цахим шуудан: www.sant.se.gov.mn  
Цахим хуудас: www.sant@selenge.gov.mn

2022.11.30. № 229  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Иймд тайлангийн төсөлд санал хүсэлт байхгүй болно.



С.ШИЖИРБААТАР



213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,  
Утас/Факс: 7036-3885

2022.12.01 № 2/253  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Холбогдох санал байхгүй болно.

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.



ОРЛОГЧ ДАРГА О.ТЦ. ПҮРЭВДОРЖ



СЭЛЭНГЭ АЙМАГ ХУШААТ СУМЫН ЗАСАГ ДАРГА


213220 Энхтан, Хушаат сум  
Утас: (02-6509) 1-43

2022.12.01 № 227  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн, гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Холбогдох санал байхгүй болно.

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.



ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ч.ГАНЗОРИГ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ШААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГА

213200 Сэлэнгэ аймаг, Шаамар сум,  
Утас:

2022. 12. 01 № 1/346  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

"Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Холбогдох санал байхгүй болно. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.



Ф. СЕРИКБОЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ЦАГААННУУР СУМЫН  
ЗАСАГ ДАРГА

213200 Цагааннуур сум, Сэлэнгэ аймаг,  
Утас/Факс: 7036-6605

2022. 12. 01 № 324  
танай 2022. 11. 23 № 152-т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

"Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Холбогдох санал байхгүй болно.



ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Б. УУГАНБАЯР

## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Шалгагдагч байгууллагуудаас холбогдох тайлбар, санал ирээгүй тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулахгүйгээр шийдвэрлэв.